



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/69

Өмнөдэлгэр сум

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Иргэний хуулийн 64 дүгээр зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3, 36.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жижиг дунд бизнесийг дэмжих сан, Сум хөгжүүлэх сангаас зээл авч хугацаа хэтрүүлсэн иргэдийн зээлийн асуудлаар иргэний хэргийн анхан шатны шүүх, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Т.Одончимэг)-г томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгч Т.Одончимэгт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 38 дугаар зүйл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 26, 26-р зүйл, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 12, 13-р зүйлийн заасан эрхийг эдлэх бүрэн эрхийг олгосугай.

3. Холбогдох баримт, бичгийг бүрдүүлж хуульд заасан эрхийг хэрэгжүүлж ажиллахыг хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Т.Одончимэг)-т үүрэг болгосугай.



Р.ЭНХТӨР